

БАГА БҮЛГИЙН БАГШИЙН АШИГЛАХ ДААЛГАВАР

Бага бүлгийн багш нь даалгавар гүйцэтгүүлэхийн өмнө үлгэр уншиж өгнө.

О.Сундуй “Алим” өгүүллэг

Бондой, Бөндэй гэдэг хоёр хулгана байжээ. Тэд хөөгөө цуглуулж яваад том улаан алим олж гэнэ. Бондой хамраа үрчилзүүлэн мушийгаад: “Алим ямар сайхан үнэртэж байна аа” гэв. Ингээд хоёулаа алимаа дамжлан гэр лүүгээ явав. Гэтэл алим гэрийнх нь үүдээр багтдаггүй шүү! Тэр хоёр янз бүрээр оролдож үзээд сүүлдээ бүр ядарч орхив.


Бондой тэсэлгүй алимаас өм хазан идээд “Янзтай” гээд толгой сэгсэрлээ.

“Хүүе ээ, тэднийг хараач” гэх дуунаар хоёул зэрэг өндийн харлаа. Гэтэл гэрийнх нь ойролцоох хулганууд байх юм гэнэ.

Харин Бөндэй: “Энэ алим гэрт маань багтахгүй байна аа” гэж хашхирлаа. Хулганууд гүйлдэн ирж том алимаас идэцгээв. Нэг мэдэхэд том улаан алимаас мөгжгор иш л үлдэж гэнэ.

Бөндэй: “За сайхан цадчихлаа” гэв.

Хулганууд, “Та хоёртоо баярлалаа. Ойрд ийм сайхан шүүслэг алим идсэнгүй” гэцгээлээ.



Даалгаврын дугаар: 1	Бүлэг: Бага
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Хэл яриа 2. Математикийн энгийн төсөөлөл
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: I	Танин мэдэхүйн түвшин: 1. Ойлгох 2. Хэрэглэх
Илрүүлэх чадвар: 1. Уншиж, ярьж өгсөн үлгэрийн агуулгыг ойлгож, асуултад 1-2 үгээр хариулах 2. 1-3 юмсыг тоолоод, дүн тоог хуруугаараа харуулах, хэлэх, улаан, шар өнгийг мэдэх	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	“Алим” үлгэр	
Хэрэглэгдэхүүн	“Алим” үлгэрийн цуврал зураг, зурагт хуудас	
Даалгаврын заавар	“Алим” үлгэрийн үйл явдлын тухай ярина. Асуултын дагуу юмсыг тоолж, дүн тоог хуруугаараа харуулах юм уу хэлнэ.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<p>1. Багш нь сая “Алим” үлгэр ярьж өглөө. Хоёулаа энэ үлгэрт юуны тухай гарсан тухай ярилцъя.</p> <p>а. Энэ юу вэ? (Алим) б. Энэ ямар амьтан бэ? (Хулгана) с. Бондой, Бөндэй хоёр юу олсон бэ? (Алим) д. Алимьг хэн идсэн бэ? (Бондой, Бөндэй, хулганууд, хулгана гэх мэт) е. Алимьг яагаад идсэн бэ? (Хаалгаар багтахгүй байсан, гоё үнэртсэн...)</p> <p>2. Математикийн энгийн төсөөлөл дээр дараах асуултыг асууна.</p> <p>а. Энд хэдэн алим байна вэ? (нэг) б. Энд хэдэн хулгана байна вэ? (хоёр) с. Алим ямар өнгөтэй байна вэ? (улаан) д. Энд хэдэн хулгана байна вэ? (гурав) е. Энэ алим ямар өнгөтэй байна вэ? (шар)</p>	<p>Үлгэрийг ярихдаа ашигласан цуврал зургийг хүүхдийн өмнө байрлуулсан байна.</p> <p>Даалгавар №1.1 дугаартай үзүүлэнг ашиглана. (тусгайлан ppt хэлбэрээр өгөгдсөн бөгөөд 1 хувь хэвлэнэ)</p> <p>Өгөгдсөн зургийг хүүхдэд эгнээ эгнээгээр харуулж асуулт асууна.</p> <p>Даалгавар №1.2 дугаартай үзүүлэнг ашиглана.</p>
Дэмжлэг	Багш хүүхдэд бодох хугацаа өгнө.	
Анхаарах зүйл	Асуултыг 1-2 удаа асууна. Асуултыг ойлгомжтой, тод хэлнэ.	

Бага бүлэг: Хэл яриа, математикийн энгийн төсөөлөл-“Алим” үлгэр

Даалгавар 1.2 (1 хувь хэвлэнэ)

Энд хэдэн алим байна вэ? Энд хэдэн хулгана байна вэ? Алим ямар өнгөтэй байна вэ?



Энд хэдэн хулгана байна вэ?



Энэ алим ямар өнгөтэй байна вэ?




Даалгаврын дугаар: 2	Бүлэг: Бага
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй, бие бялдар	Сургалтын чиглэл: 1. Байгаль, нийгмийн орчин 2. Эрүүл мэнд 3. Математикийн энгийн төсөөлөл
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: I	Танин мэдэхүйн түвшин: 1. Сэргээн санах 2. Үнэлэх 3. Ойлгох
Илрүүлэх чадвар: 1. Орчны юмсыг таньж авч ирэх 2. Идэж болдог, болдоггүй зүйлсийг мэдэх, хэрэглэх 3. Дээр, доор гэсэн байрлал заасан үгийг ойлгох, хэрэглэх	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	Эд юмс	
Хэрэглэгдэхүүн	Зурагт хуудас (алим, ном, саван, бялуу, зайрмаг, харандаа), ном, харандаа, бөмбөг, тоглоом	
Даалгаврын заавар	Багшийн хэлсэн өгүүлбэрийг дагаад хэлээрэй.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	1. Ширээн дээр байгаа зургуудыг ажиглаад хараарай. Багшийнхаа хэлсэн зүйлийг аваад өгөөрэй. <ol style="list-style-type: none"> Багшдаа ном аваад өгөөрэй. Одоо харандаа аваад өгөөрэй. Багшдаа саван аваад өгөөрэй. Багшдаа зайрмаг аваад өгөөрэй. Багшдаа алим аваад өгөөрэй. 2. Зургийг нэрлээд, идэж болно, болохгүй гэдгийг хэлнэ. <ol style="list-style-type: none"> Энэ юуны зураг вэ? (алим). Алимьг идэж болох уу? (болно) Энэ юуны зураг вэ? (харандаа). Харандааг идэж болох уу? (болохгүй) Энэ юуны зураг вэ? (зайрмаг). Зайрмагийг идэж болох уу? (болно) Энэ юуны зураг вэ? (саван). Саванг идэж болох уу? (болохгүй) Энэ юуны зураг вэ? (бялуу). Бялууг идэж болох уу? (болно) 	Зурагт хуудсаар өгөгдсөн зургуудыг хайчилж тараах материал болгож бэлтгэсэн байна. Даалгавар №2.1 дугаартай үзүүлэнг ашиглана. Хүүхдэд зураг харуулж ярилцана. Даалгавар №2.1 дугаартай үзүүлэнг ашиглана.

	<p>3. Багшийнхаа хэлсэн байрлалд тоглоомыг байрлуулж тавиарай.</p> <p>a. Ширээн дээр ном тавиарай.</p> <p>b. Ширээн доор бөмбөг тавиарай.</p> <p>c. Тоглоомыг сандал дээр тавиарай.</p> <p>d. Харандааг сандал доор тавиарай.</p>	<p>-Багш ном, тоглоом, бөмбөг, харандаа бэлтгэсэн байна.</p>
Дэмжлэг	Багш хүүхдэд бодох хугацаа өгч хүлээнэ.	
Анхаарах зүйл	-Багш асуулт асуухдаа гараараа тухайн зүг рүү заахгүй байхыг анхаарна уу. Өөрөөр хэлбэл ширээн дээр юу байна вэ? гэж асуухдаа ширээний дээд тал руу заахгүй.	

Бага бүлэг: Байгаль, нийгмийн орчин, эрүүл мэнд, математикийн энгийн төсөөлөл – “Эд юмс” Даалгавар №2.1 (1 хувь хэвлэнэ)





Даалгаврын дугаар: 3	Бүлэг: Бага
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Дүрслэх урлаг 2. Нийгэмшихүй
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: I	Танин мэдэхүйн түвшин: 1. Бүтээх 2. Хэрэглэх
Илрүүлэх чадвар: 1. Баримлын шаврыг гонзгойлж, бөөрөнхийлж алим барих 2. Багшийн тусламжтайгаар тоглоом, эд зүйлсийг хэрэглэх, буцааж байранд нь хураах	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	Баримлаар алим хийе	
Хэрэглэгдэхүүн	Алим хийх аргачлал, баримлын суурь, хормогч, баримлын шавар	
Даалгаврын заавар	Багшийн тусламжтайгаар аргачлалын дагуу баримлын шавраар алим барина.	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	<p>1. Энэ юу вэ? Баримлын шавар. Одоо баримлын шавраар алим хийе. Чи ямар өнгөтэй алим хийхийг хүсэж байна вэ? Өнгөө сонгоорой. Баримлаас тастаж аваарай. Баримлын шавраа базаж зөөллөөрэй.</p> <p>а. Баримлын суурин дээр юм уу хоёр гарын алганы завсар хийж эргүүлээд бөөрөнхий болгоорой.</p> <p>б. Бөөрөнхийлсөн шаврын аль нэг хэсэгт хуруугаар дарж хонхойлгоорой.</p> <p>с. Одоо иш хийх жижиг баримал тастаж аваарай. Баримлаа баримлын суурин дээр тавьж, дээрээс нь дараад нааш, цааш хөдөлгөн гонзгой болгоорой. (Баримлыг алганы завсар хийж гарын алгыг зөрүүлэн дээш доош хөдөлгөн гонзгойлж болно)</p> <p>д. Баримлын хонхойлгосон хэсэгт иш хийх баримлын нэг үзүүрийг дарж холбоорой.</p> <p>2. Хэрэглэсэн зүйлсээ хураагаарай. (цэгцлэх)</p>	<p>Баримлыг тохируулан тасалж авахад нь тусална.</p> <p>Даалгавар №3.1 дугаартай үзүүлэнг ашиглана.</p> <p>Багш баримлыг бөөрөнхийлөх, гонзгойлох үйлийг дагуулж хийлгэнэ.</p>
Дэмжлэг	Иш хийх жижиг баримлыг таслахад багш тусална.	
Анхаарах зүйл	Багш хүүхдийн хэрэглэж буй баримлын шаварт хүрэхгүй бөгөөд өөр баримлаар биечлэн хийж үзүүлнэ.	

Бага бүлэг: Дүрслэх урлаг, Нийгэмшихүй – “Баримлаар алим хийе”

Даалгавар №3.1 (1 хувь хэвлэнэ)



Даалгаврын дугаар: 4	Бүлэг: Бага
Хөгжлийн чиглэл: Танин мэдэхүй	Сургалтын чиглэл: 1. Хэл яриа
Сургалтын хөтөлбөрийн чадварын түвшин: I	Танин мэдэхүйн түвшин: 1. Задлан шинжлэх
Илрүүлэх чадвар: 1. Хураангуй өгүүлбэр хэлэх	Интеграц эсэх: Тийм
Даалгаврыг гүйцэтгэх хугацаа: Хүүхдийн гүйцэтгэлээр	Даалгаврын хэлбэр: Задгай

Даалгавар	Хэн юу хийж байна вэ?	
Хэрэглэгдэхүүн	Үйл явдал харуулсан 4 зураг	
Даалгаврын заавар	Зургийг анхааралтай ажиглаарай. Хэн юу хийж байна вэ?	
Даалгаврыг явуулах аргачлал	Багшийн хэлэх үг	Багшийн хийх үйлдэл
	1. Багш нь чамд зураг үзүүлэе. a. Энэ зурагт хүүхэд юу хийж байна вэ? (Хүүхэд зураг зурж байна) b. Энэ зурагт хүүхэд юу хийж байна вэ? (Хүүхэд хоолоо идэж байна, хүүхэд алим идэж байна) c. Энэ зурагт хүүхэд юу хийж байна вэ? (Хүүхэд ном үзэж байна) d. Энэ зурагт хүүхэд юу хийж байна вэ? (Хүүхэд тоглож байна)	Үйл явдал харуулсан 4 зургийг нэг нэгээр нь хүүхдийн өмнө тавьж “Хэн юу хийж байна вэ?” гэж асууна. Даалгавар №4.1 дугаартай үзүүлэнг ашиглана.
Дэмжлэг	Хүүхдэд зургийг ажиглах, бодох хугацаа олгоно.	
Анхаарах зүйл	Багш асуултыг нэг л удаа асууна.	

Бага бүлэг: Хэл яриа- “Хэн юу хийж байна вэ?” Даалгавар №4.1 (1 хувь хэвлэнэ)

